



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 1/39

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9 дэх заалт, Улсын Их Хурлын 2019 оны "Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай" 07 дугаар тогтоол, 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 5.4 дэх заалт, 2019 оны "Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" 18 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Ажлын албаны үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн "Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" А/30 дугаар тушаалын хавсралтын "3.Гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийн үр нөлөө хариуцсан референт, орон тоо 1" гэснийг "3.Дотоод аудит хариуцсан референт, орон тоо 1" гэж өөрчлөлт оруулсугай.

2.Тушаалын хавсралтын өөрчлөлттэй холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Захиргаа, удирдлагын газар (Ж.Жамъянтив)-д даалгасугай.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.АМАРТӨГС